

Дэлхий даяарх Тэнгэрлэг  
Эцэгийн хүүхдүүдийн  
талаар олж мэд.

# ПАПУА НЮ ГИНИГЭЭС МЭНДЧИЛЖ БАЙНА!

Папуа Ню Гини бол Номхон далайн арлын орон юм. Энэ нь Шинэ Гвиней арлын тэн хагасыг эзэлдэг. 8 сая гаруй хүн энд амьдардаг!

## ЦУГЛААНЫ БАЙРУУД

Папуа Ню Гинид үер болох нь элбэг. Тиймээс Сүмийн байрууд модон хөлтэй суурин дээр баригдсан байдаг. Үер болох үед гишүүд гэр лүүгээ завьтай сэлүүрдээд гэрийнхээ яг үүдэнд очдог!




## ШИРЭНГЭН ОЙН ШУВУУД

Диваажингийн шувууд нь ширэнгэн ойн ичимхий шувууд юм. Эрэгчнүүд нь маш гоёмсог, өнгөлөг далавчтай. Раггиана диваажингийн шувуу нь энэ улсын далбаан дээр байдаг.

Yu stap guf?

гэдэг нь ток писин хэлээр "Чи сайн уу?" гэсэн үг юм!

ЗУРАГ, ЧИМЭГЛЭЛИЙГ ЭЭН ЛЬО



## SING-SINGS (ДУУН НААДАМ)

Папуа Ню Гини овгууд дуулж, бүжиглэж, уламжлалаа хувалцаж, найз нөхөд болохоор цуглардаг. Хамгийн том дуун наадамд жил бүр 100 гаруй овог оролцдог.



Папуа Ню Гини дэлхийн аль ч улсаас олон хэлтэй буюу ойролцоогоор 840 хэл ашигладаг!



ҮЙЛ  
АЖИЛЛАГАА

## Аварга том эрвээхэйнүүд

Папуа Ню Гинид хамгийн том эрвээхэйнүүд байдаг! Өөрийн эрвээхэйг хийгээрэй. Мөчир, навч, цэцэг ашиглан эрвээхэйн дүрс хий. Баруун талд буй шугамыг ашиглан хийсэн эрвээхэйнийхээ далавчийг хэмжээд үзээрэй.

Хатан хаан Александра гэх эрвээхэйн далавчийн урт: 28 см (11 инч)



ЖОР

## Тогооны тахиа

Энэ бол Папуа Ню Гинийн үндэсний хоолны жор. Энэ хоолыг хийгээд үзээрэй!

- 1 кг хэрчсэн тахианы махаа тогоонд хийгээд дээрээс нь **тал хоолны халбага** ургамлын тос хийнэ. **1 цайны халбага** нунтаг карри, **1 цайны халбага** давс нэмнэ.
- 1 **чихэрлэг төмс** (эсвэл өөр ногоо), **хэдэн ширхэг ногоон сонгино** хэрчинэ. Үүнийгээ **1 аяга эрдэнэ шишийн** хамт тогоондоо хийнэ.
- Мах болон ногоон дээрээ **тал аяга наргил модны самрын тос** хийнэ. Тогоогоо таглаад бага галаар буцалгана. 30-40 минут зөөлөн буцалгаарай.

Томчуудаас тусламж аваарай!